



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/04/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: <b>Ш.Мөнхбаяр</b> Утас: <b>7037-3089</b> Цахим хаяг: <a href="mailto:munkhbayarsh@audit.gov.mn">munkhbayarsh@audit.gov.mn</a> Ахлах аудитор: <b>С.Батцэцэг</b> Утас: <b>7037-3089</b> Цахим хаяг: <a href="mailto:battsetsegs@audit.gov.mn">battsetsegs@audit.gov.mn</a> Аудитор: <b>Ч.Цэрэннадмид</b> Утас: <b>9511-2689</b> Цахим хаяг: <a href="mailto:tseb.audit@gmail.com">tseb.audit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	134
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл, урлагийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45053 Дархан-Уул аймаг  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН СУМЫН 4 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

2022.02.25 № 196

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/



009020193




2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>55,536,472.72</b>	<b>59,930,213.82</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>55,536,472.72</b>	<b>59,930,213.82</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>18,074,793.72</b>	<b>15,843,500.82</b>
35110	Тусгай зориулалттай материал	15,379,373.72	14,669,840.12
35130	Эм боох материал	2,695,420.00	1,173,660.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>37,461,679.00</b>	<b>44,086,713.00</b>
35410	Бичиг хэргийн материал	838,100.00	818,100.00
35420	Аж ахуйн материал	35,468,829.00	41,373,569.00
35460	Хүнсний материал	1,154,750.00	1,619,444.00
35470	Бусад хангамжийн материал		275,600.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,978,121,182.95</b>	<b>1,913,636,026.46</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,978,121,182.95</b>	<b>1,913,636,026.46</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>1,639,649,864.54</b>	<b>1,575,389,568.01</b>
39201	Барилга байгууламж	1,590,123,532.86	1,590,123,532.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,383,230.43)	(145,266,871.15)
39205	Машин тоног төхөөрөмж	34,177,261.00	33,817,361.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,984,963.02)	(14,055,382.10)
39207	Тавилга, эд хогшил	26,903,796.60	27,257,918.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,370,344.01)	(15,091,350.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	124,603,000.47	124,603,000.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,450,790.00)	(29,030,242.16)
39217	Ном	3,031,601.07	3,031,601.07
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>338,471,318.41</b>	<b>338,246,458.45</b>
39301	Программ хангамж	2,536,800.00	1,124,300.00
39302	Хасагдуулга	(1,843,481.59)	(655,841.55)
39303	Бусад биет бус хөрөнгө	337,778,000.00	337,778,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,033,657,655.67</b>	<b>1,973,566,240.28</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,033,657,655.67</b>	<b>1,973,566,240.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,033,657,655.67</b>	<b>1,973,566,240.88</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	614,804,634.00	614,804,634.00
51101	Өмч: -төрийн	614,804,634.00	614,804,634.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(238,119,030.32)</b>	<b>(298,210,445.11)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(202,323,753.35)	(238,119,030.32)
51220	Тайлант үеийн үр дүн	(35,795,276.97)	(60,091,414.79)
51300	Дахин үнэлгээний зөрүү	1,656,972,051.99	1,656,972,051.99
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,033,657,655.67</b>	<b>1,973,566,240.88</b>





2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>626,316,661.00</b>	<b>580,123,240.70</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,020,361.00</b>	<b>5,000,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>32,020,361.00</b>	<b>5,000,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,020,361.00	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	32,020,361.00	1,200,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,800,000.00
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>594,296,300.00</b>	<b>575,123,240.70</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>552,721,100.00</b>	<b>540,800,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих	552,721,100.00	540,800,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>640,000.00</b>	<b>358,140.70</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	500,000.00	183,140.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	175,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,935,200.00</b>	<b>33,965,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,935,200.00	33,965,000.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>662,111,937.97</b>	<b>640,214,655.49</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>662,111,937.97</b>	<b>640,214,655.49</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>644,658,916.71</b>	<b>634,106,766.54</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>431,185,169.00</b>	<b>443,211,174.97</b>
210101	Үндсэн цалин	401,593,655.00	386,639,087.97
210102	Нэмэгдэл цалин		29,808,661.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		19,800.00
210104	Урамшуулал	29,591,514.00	26,743,626.00
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>55,438,478.67</b>	<b>54,973,554.83</b>
210201	Тэтгэврийн даатгалын	38,410,482.30	38,003,841.67
210202	тэтгэмжийн даатгалын	4,518,875.02	5,027,680.93
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,477,344.07	3,850,784.72
210204	Ажилгүйдлийн даатгалын	821,073.80	918,512.68
210205	ЭМ-ийн даатгалын	8,210,703.48	7,172,734.83
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,699,651.07</b>	<b>20,665,596.25</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	971,867.60	4,678,018.42
210302	Түлш, халаалтын зардал	8,967,613.63	13,339,410.83
210303	Цэвэр бохир усны зардал	3,760,169.84	2,648,167.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,954,331.08</b>	<b>3,320,793.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	380,000.00	560,200.00



210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	500,000.00	447,500.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	279,500.00	631,400.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	440,350.00	244,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	6,354,481.08	1,437,593.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,952,012.50</b>	<b>33,601,291.00</b>
210502	Хоол, хүнс	43,792,712.50	31,985,691.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,159,300.00	1,615,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,807,800.00</b>	<b>10,645,800.00</b>
210604	Урсгал засварын зардал	26,807,800.00	10,645,800.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>		
210702	Дотоодын томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>750,100.00</b>	<b>605,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	169,600.00	
210802	Аудит баталгаажуулалтын зардал	580,500.00	580,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		25,400.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,871,374.39</b>	<b>67,082,656.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		140,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	815,600.00	353,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,055,774.39	66,588,756.49
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>17,453,021.26</b>	<b>6,107,888.95</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>379,748.93</b>	<b>536,603.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	379,748.93	536,603.75
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,073,272.33</b>	<b>5,571,285.20</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,073,272.33	5,571,285.20
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(35,795,276.97)</b>	<b>(60,091,414.79)</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	-	-
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(35,795,276.97)</b>	<b>(60,091,414.79)</b>





**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/Төгрөгөөр/**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	614,804,634.00	1,656,972,051.99	(202,323,753.35)	2,069,452,932.64
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(35,795,276.97)	(35,795,276.97)
<b>2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	614,804,634.00	1,656,972,051.99	(238,119,030.32)	2,033,657,655.67
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(60,091,414.79)	(60,091,414.79)
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	614,804,634.00	1,656,972,051.99	(298,210,445.11)	1,973,566,240.88






2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>594,296,300.00</b>	<b>575,123,240.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>594,296,300.00</b>	<b>575,123,240.70</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	552,721,100.00	540,800,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>640,000.00</b>	<b>358,140.70</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	500,000.00	183,140.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	140,000.00	175,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,935,200.00</b>	<b>33,965,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,935,200.00	33,965,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>594,296,300.00</b>	<b>574,219,640.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>594,296,300.00</b>	<b>574,219,640.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>576,843,278.74</b>	<b>568,111,751.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>429,909,547.67</b>	<b>439,234,815.62</b>
210101	Үндсэн цалин	332,455,262.67	293,048,469.12
210102	Нэмэгдэл	67,832,229.00	119,590,479.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,064,000.00	19,800.00
210104	Урамшуулал	26,558,056.00	26,576,067.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,659,100.00</b>	<b>58,949,914.18</b>
210201	Тэтгэврийн даатгалын	38,787,127.26	41,443,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын	3,434,300.00	4,339,700.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,188,400.00	3,567,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,779,672.74	878,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	8,469,600.00	8,720,214.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,699,651.07</b>	<b>20,665,596.25</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	971,867.60	4,678,018.42
210302	Түлш, халаалтын зардал	8,967,613.63	13,339,410.83
210303	Цэвэр бохир усны зардал	3,760,169.84	2,648,167.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>4,641,900.00</b>	<b>1,821,040.70</b>
210401	Бичиг хэргийн зардал	380,000.00	467,500.00
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	500,000.00	447,500.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,616,600.00	361,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,145,300.00	544,640.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,247,180.00</b>	<b>33,358,685.00</b>
210501	Эм	2,243,800.00	180,700.00
210502	Хоол, хүнс	38,791,380.00	32,450,385.00
210503	Нормын хувцас	1,212,000.00	727,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>27,305,800.00</b>	<b>12,762,800.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	450,000.00	
210604	Урсгал засвар	26,855,800.00	12,762,800.00



2107	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоодын томилолт	-	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>750,100.00</b>	<b>768,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,600.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		187,800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,630,000.00</b>	<b>550,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	880,000.00	240,600.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	310,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,453,021.26</b>	<b>6,107,888.95</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>379,748.93</b>	<b>536,603.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	379,748.93	536,603.75
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	<b>17,073,272.33</b>	<b>5,571,285.20</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,073,272.33	5,571,285.20
3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>903,600.00</b>
5	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	-	<b>903,600.00</b>
22	<b>Хөрөнгийн зардал</b>	-	<b>903,600.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>903,600.00</b>
223001	Бусад хөрөнгө		903,600.00
6	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>(903,600.00)</b>
7	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
8	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		






**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/Төгрөгөөр/**

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	578,862,900.00	568,657,211.05	10,205,688.95	98.2
21	Урсгал зардлын дүн	578,862,900.00	568,657,211.05	10,205,688.95	98.2
210	Бараа үйлчилгээний зардал	578,862,900.00	568,657,211.05	10,205,688.95	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,294,200.00	439,234,815.62	45,251.38	100.0
210101	Үндсэн цалин	294,738,000.00	293,048,469.12	1,689,530.88	99.4
210102	Нэмэгдэл	117,946,200.00	119,590,479.50	(1,644,279.50)	101.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,800.00	19,800.00	-	100.0
210104	Урамшуулал	26,590,200.00	26,576,067.00	14,133.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,015,500.00	58,949,914.18	65,585.82	99.9
210201	Тэтгэврийн даатгал	41,443,900.00	41,443,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,339,700.00	4,339,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,567,500.00	3,567,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	878,600.00	878,600.00	-	100.0
210205	ЭМД-ын хураамж+В21	8,785,800.00	8,720,214.18	65,585.82	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,300,000.00	20,665,596.25	4,634,403.75	81.7
210301	Гэрэл цахилгааны зардал	5,800,000.00	4,678,018.42	1,121,981.58	80.7
210302	Түлш, халаалтын зардал	16,000,000.00	13,339,410.83	2,660,589.17	83.4
210303	Цэвэр бохир усны зардал	3,500,000.00	2,648,167.00	851,833.00	75.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,462,900.00	1,462,900.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	292,500.00	292,500.00	-	100.0
210403	Шуудан холбоо	447,500.00	447,500.00	-	100.0
210405	Хог хаягдал	361,400.00	361,400.00	-	100.0
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	361,500.00	361,500.00	-	100.0
2105	Нормативт зардал	39,687,100.00	34,262,285.00	5,424,815.00	86.3
210501	Эм	180,700.00	180,700.00	-	100.0
210502	Хоол хүнс	37,875,200.00	32,450,385.00	5,424,815.00	85.7
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,631,200.00	1,631,200.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,762,800.00	12,762,800.00	-	100.0
210601	Багаж хэрэгсэл				
210604	Урсгал засвар	12,762,800.00	12,762,800.00		100.0





Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	768,300.00	768,300.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр			-	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ			-	
210804	Тээврийн хэрэгслийн татвар			-	
	Даатгалын үйлчилгээ			-	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			-	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	187,800.00	187,800.00	-	100.0
210807	Газрын төлбөр			-	
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	572,100.00	550,600.00	21,500.00	96.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	262,100.00	240,600.00	21,500.00	91.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	310,000.00	310,000.00	-	100.0
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	578,862,900.00	568,657,211.05	10,205,688.95	98.2
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	540,800,100.00	535,228,814.80	5,571,285.20	99.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	540,800,100.00	535,228,814.80	5,571,285.20	99.0
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	38,062,800.00	33,428,396.25	4,634,403.75	87.82
132001	Орон нутгийн төсвөөс	38,062,800.00	33,428,396.25	4,634,403.75	87.82
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	-	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих			-	
002	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	
003	Төсвийн байгууллага			-	
	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	39.00	-	39.00	0.0
	Удирдах ажилтан	1.00		1.00	0.0
	Гүйцэтгэх ажилтан	33.00		33.00	0.0
	Үйлчлэх ажилтан	5.00		5.00	0.0





**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		358,140.70	(358,140.70)
21	Урсгал зардал		358,140.70	(358,140.70)
210	Бараа ажил үйлчилгээний зардал		358,140.70	(358,140.70)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	358,140.70	(358,140.70)
210401	Бичиг хэрэг	-	175,000.00	(175,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		183,140.70	(183,140.70)
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		358,140.70	(358,140.70)
1311	Нэмэлт санхүүжилтийн тайлан		358,140.70	(358,140.70)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		175,000.00	(175,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		183,140.70	(183,140.70)





## **Аудитын тайлан**

### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр цэцэрлэгийн /цаашид 4 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Э.Эрдэнэбат нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**


Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 662,111.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,621.1 мянган төгрөгөөр,





гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,634.8 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,091.5 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

төгрөг/	/мянган		
Үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	55,536.5	59,930.2	4,393.7
Үндсэн хөрөнгө	2,119,154.0	2,117,735.7	(1,418.3)
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(141,032.8)	(204,099.7)	(63,066.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,033,657.7</b>	<b>1,973,566.2</b>	<b>(60,091.5)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	2,033,657.7	1,973,566.2	(60,091.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,033,657.7</b>	<b>1,973,566.2</b>	<b>(60,091.5)</b>

Бараа материал дансны үлдэгдэл 4,393.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 47,246.0 мянган төгрөгийн материал худалдан авсан, хандиваар 3,800.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хүлээн авч, 46,652.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 1,418.3 мянган төгрөгөөр буурсан нь 903,6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 1,200.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, Дархан Уул аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 01А/398 дугаар захирамжаар 1,559.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 549,5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,412.5 мянган төгрөгийн программ хангамж нийт 3,521.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устган данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд 66,588.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,973,566.2 мянган төгрөг болж 60,091.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 46,193.4 мянган төгрөгөөр буюу 7,4 хувиар буурахад тусламж, санхүүжилтийн орлого 19,173.1 мянган төгрөг, татварын бус орлого 27,020.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Урсгал зардал өмнөх оноос 21,897.3 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ-ийн зардал 11,561.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,965.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,211.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 4,633.5 мянган төгрөг, норматив зардал 12,350.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 144,2



мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын 16,162.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 11345.1 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 845,699.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн төслийг өмнөх оны батлагдсан төсвөөс 250,638.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж төсвийн захирагчид хүргүүлсэн ч 266,836.1 мянган төгрөгөөр бууруулж, 578,862.9 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал: Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 27,980.9 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 24,364.9 мянга, хангамж бараа материалын зардал 5,105.9 мянга, норматив зардал 106,649.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан ба тайлант онд гүйцэтгэлээр цалин 125.0 мянган төгрөг, норматив зардал 5,424.8 мянган төгрөг, түлш халаалтын зардал 4,634.4 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс зарцуулагдаагүй үлдсэн байна. Үүнээс харахад төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна гэж хэлэхээр байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 578,862.9 мянган төгрөгийн төсөв баталсныг бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.


Зардлыг санхүүжүүлэхээр 578,862.9 мянган төгрөгийн төсөв баталсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 540,800.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 38,062.8 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 540,800.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33,965.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 568,657.2 мянган төгрөг зарцуулж, 6,107.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 568,657.2 мянган төгрөг буюу 98,24 хувьтай байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшил 125.0 мянган төгрөг, тогтмол зардал 4,634.4 мянган төгрөг, норматив зардал 5,424.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 21,5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.





Нэмэлт санхүүжилтийн дансаар БСУГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтийн 183,1 мянган төгрөг, тендерийн орлого 175.0 мянган төгрөг нийт 358.1 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг зориулалтын дагуу зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээллийг бүрэн оруулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**


Өмнөх оны аудитаар 3,595.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 42,667.6 мянган төгрөгийн зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 237.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 237.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.





#### 4.1 Зөвлөмж

##### 1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

##### 1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Өмнөх оны санхүүгийн тайланд өр үүсгэлгүйгээр 237.4 мянган төгрөгийн ХХОАТ-ийг тайлант жилийн төсвөөс зарцуулсан, Татварын албатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 14.4.4 дэх заалт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэн”, 14.4.3 дахь “Бүх өр төлбөр” гэж заасантай нийцээгүй тул харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	4 дүгээр цэцэрлэг	1	237.4	-	-	-	-			1	237.4

